ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)[1]

ЗАСГИЙН ГАЗАР ӨӨРИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ШИЛЖҮҮЛЭН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ НЬ ХУУЛЬД НИЙЦЭХГҮЙ

САНАМЖ: *Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.*
Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2026/0070
Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдөр
Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 51 тоот тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл[2], Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2[3]-т заасныг тус тус үндэслэн Барилгын тухай хуульд заасан барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зарим чиг үүргийг “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайдад зөвшөөрсөн байна.

Харин нэхэмжлэгч хуулийн этгээд нь Засгийн газарт барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг бусдад шилжүүлэх эрх олгогдоогүй тул түүний чиг үүргийг өөр этгээдээр гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрх олгосон нь хуульд нийцэхгүй. Мөн сонгон шалгаруулалт хийлгүйгээр “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай гэрээ байгуулах эрх олгосон нь нэг этгээдэд давуу байдал олгож, барилгын ижил төрлийн байгууллагуудыг өрсөлдөх боломжгүй болгосон гэх үндэслэлээр Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 51 тоот тогтоолыг илт хууль бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. ***Давж заалдах шатны шүүхээс (анхан шатны журмаар):*** “...хариуцагч Засгийн газар нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон Барилгын тухай хуулийн холбогдох заалтуудаар барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр шилжүүлэх бүрэн эрхтэй бөгөөд уг эрхийнхээ хүрээнд маргаан

---

[1] Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3519?daterange=2026-01-01%20-%202026-10-12&id=3&court_cat=3&bb=1.

[2] Монгол Улсын Засгийн газрын тухай хууль (1993)-ийн 19 дүгээр зүйл “*Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх*”

[3] Барилгын тухай хууль (2016)-ийн 34 дүгээр зүйлийн 34.2 “*Энэ хуулийн 34.1.2, 34.1.3, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.14, 34.1.15-д заасан чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно*”

бүхий Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолыг гаргасан, энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3[4], 47.1.5[5]-д заасан илт хууль бус захиргааны актын шинжийг агуулаагүй" гэх үндэслэлээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

2. ***Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зүгээс:*** "...маргаан бүхий тогтоол нь бусдад өрсөлдөөнгүйгээр давуу байдал үүсгэж, бусдын эрх ашгийг хохироосон байхад шүүх бодитой дүгнэлт хийгээгүй ... эрх ашиг хөндөгдөх этгээдүүдийн оролцоог хангаагүй ... нэхэмжлэгчийн эрх ашиг хөндөгдөөгүй хэмээн тайлбарлаж шийдвэрлэсэн нь хуульд нийцэхгүй ..." зэрэг үндэслэлээр давж заалдах журмаар гомдол гаргасан.
3. ***Хяналтын шатны шүүхээс*:** Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр, гэрээний үндсэн дээр бусад этгээдэд шилжүүлэх эрхтэй бөгөөд **гагцхүү тухайн этгээд нь Засгийн газрын бус, төрийн бус мэргэжлийн байгууллага байх шаардлагатай**. Өөрөөр хэлбэл, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг **төрийн оролцоо хамааралгүй мэргэжлийн байгууллагад шилжүүлэх**ийг зөвшөөрсөн агуулгатай байна. (12)[6]
4. Гэтэл Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор Барилгын тухай хуулийн 34.1.2, 34.1.4, 34.1.6, 34.1.7, 34.1.8, 34.1.9, 34.1.10, 34.1.11, 34.1.13, 34.1.15-д заасан барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр Барилга, хот байгуулалтын сайдад зөвшөөрсөн нь "Засгийн газрын бус", "төрийн бус, мэргэжлийн байгууллага" гэдэг хуульд заасан нөхцөлд хамаарна гэж үзэхээргүй байна. (13)
5. Тухайлбал, Барилгын хөгжлийн төв нь Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 47 дугаар тогтоолоор "Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга, захиалагчийн алба" улсын үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулж бий болгосон **100 хувийн төрийн хөрөнгө оруулалттай төрийн өмчит хуулийн этгээд байна**. Иймээс Барилгын хөгжлийн төв нь барилгын салбарын мэргэжлийн чиг үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхээс үл хамааран Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1, Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасан шаардлагыг хангахгүй байна. (14)
6. Дээрх үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэсэн.

-o0o-

[4] Захиргааны ерөнхий хууль (2015)-ийн 47 дугаар зүйлийн 47.1.3 "*тухайн захиргааны байгууллага өөрийн чиг үүрэгт үл хамаарах асуудлаар захиргааны акт гаргасан*"
[5] ЗЕХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1.5 "*хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг гүйцэтгэхийг шаардсан*"
[6] "Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр" хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.